

## СИСТЕМИЙН ОНОЛ БА ЁС ЗҮЙН СУРГААЛЫН ЗАРИМ АСУУДАЛ

**Түлхүүр үг:** хүмүүний оршихуйг нэгдмэлжүүлэх, нөхөн сэргээх үндсүүд, амьдрал, ухамсар, ертөнцийн тэнцвэр, тарнийн танин мэдэхүй.

Өнөөгийн манай цаг үед хүний оршихуйн суурь үндсүүдийг тодруулах явдал нэн чухал болсон байна. Нэгдмэл орон зай, тэнцвэрийг нөхөн олох байгалийн жам ёсны гинжин холбоо байх буюу ертөнцийн оршихуйг нэгдмэлжүүлэх үндэс буй.

Танин мэдэхүйн материалист, эмпирик аргыг хөгжүүлж ирсэн шинжлэх ухаан, нийгмийн практикийн бодит үйл явцын эцсийн үр дүнд оюун санаа-ёс суртахууны хямрал хамгийн бодитой болсон төдийгүй энэ хямрал хүний үйл ажиллагааны бүх хүрээ салбарт улам бүр нөлөөтэй болсоор байна.

Ийм нөхцөлд амьдрал, ухамсар, хариуцлага, ёс суртахууны үнэт зүйлс, хэм хэмжээний асуудлуудыг дахин шинээр тавьж ухаарах явдал нь хэн бүхэнд нэн чухал болсоор байна.

Оюун санаа-ёс суртахууны хямрал, байгаль-экологийн сүйрлийн дохио, дайн-энхийн асуудлууд, одоогийн хүн төрөлхтөнөөс оршихуйн суурь үндсүүдээ шинээр тодорхойлохыг шаардаж байна.

1. Хүмүүний оршихуйг нэгдмэлжүүлэх, нөхөн сэргээх үндсүүд зайлшгүй байх учиртайг хүн бүр их бага хэмжээнд ухаарч байгаа. Байгаль-ертөнцийн тэнцвэрийг нөхөн сэргээх гинжин холбоо бол гагцхүү бидний **санаа сэтгэлийн ба оюун ухааны хөдөлгөөн** болохыг ойлгох хандлага руу бид эргэлт буцалтгүй явж байна. Энэ бол хүн төрөлхтөний хөгжлийн шинэ үе шатны угтвар нөхцөл байдал байх юм.

Хүн бүрт **ухамсар** ба үйл байдлын өвөрмөц шинж төлөв байна. Ухамсар төгс бус байдаг нь хүн өөрийнхөө дотоод мөн чанарыг зөв танин хөгжүүлдэггүйгээс хамаарч байна. Хүн дотоод мөн чанараасаа эхлэн төгөлдөржиж байж гадаад ертөнцийг цаашид зүй зохистойгоор өөрчлөн хувиргах чадвартай болно. Үүний дотор өөрийн амьдрал, жаргал зовлонгийн

асуудлыг ч шийдвэрлэх чадварыг хүн өөрийнхөө дотоод мөн чанарт хадгалан явдаг учиртай ажээ. Гагцхүү тэр чадвараа эрт орой, чухам хэдийд нээх нь мөн л өөрөөс нь хамаарах зүй тогтолтой байдаг аж.

**Гэвч зохистой үйлдэхүйн асуудал нь зөвхөн тухайн нэгэн хүмүүнд хамааралтай асуудал бус юм.**

**2. Амьдралын тухай асуудал нь оршихуйг нэгдмэлжүүлэх, нөхөн сэргээх асуудалтай нягт холбоотой .**

Амьдрал бол байгаль ертөнцийн суурь шинж чанар мөн бөгөөд үүнийг материаллаг элементүүдийн жирийн нэгэн хэлхээ хэмээн ойлгох боломжгүй. Амьдрал бол тоон хэмигдхүүнээр хэмжиж үл болох байгаль дахь мэдээллийн урсгалын нэг хэлбэр юм.

Өрнөдийн уламжлалт шинжлэх ухаан амьдралын тухай асуудлыг дан ганц материаллаг үндэслэлээс тайлбарлахдаа амьдралын үүслийн асуудлыг тайлбарлах шатанд энэхүү материйн **apriori** чанарыг онцлон үзэхээс өөр аргагүй байдалд хүрч байсныг бид сайн мэдэх билээ.

Ердийн матери асар их хэмжээний мэдээллийн агуулгатай байдаг. Жишээлбэл, жирийн нэгэн байгалийн чулуу олон сая тэртээх амьдралын нэгэн хэлбэрийн тухай бараг хэмжиж үл болох их хэмжээний мэдээллийг өөртөө хадгалж байна.

Гэтэл одоо амьд байгаа биетүүдийг тодорхойлоход мэдээллийн асар их багтаамж хэрэгтэй болох нь тодорхой. Энэ амьдралын үндсэнд байгаа мэдээлэл нь ертөнцийн суурь хуулинд туссан байх тухай байгаль шинжлэлийн шинэхэн ололтууд нотлох болов.

Энэ хуулиуд нь "абсолют бодит байдалд нийцсэн байдаг, иймд амьдралын үндсэнд байгаа мэдээлэл туйлын чанартай байна" гэж зарим судлаачид үзэж байна. (Richard L. Thompson. Mechanistic and non mechanistic science)

3. Молекуляр түвшинд тайлбарлах боломжгүй амьдралын нэгэн шинж чанар бол **ухамсар** юм. Бие хүн бол амьдрал бодитой хэрэгжсэн тодорхой хэлбэр буюу ухамсарт чанартай хөдөлгөөний хэлбэр юм. Гэвч орчин үеийн шинжлэх ухаан нь ухамсрын тухай хангалттай мэдээ, мэдлэгийг хуримтлуулж чадаагүй байгаа тул бид

бие хүний тухай асуудлыг иж бүрэн дэлгэн тайлбарлах бололцоогүй байсаар байна.

Гагцхүү ухамсрыг хялбар материаллаг элементүүдэд хуваан задалснаар түүний уг чанарыг тайлбарлах бололцоогүй гэдгийг сүүлийн үеийн шинжлэх ухааны ололтууд тодорхой нотолж байна. Иймд хүний тухай асуудлыг материаллаг үндэслэлээс тайлбарлах ямар ч бололцоогүй юм.

К.Поппер: хүн төрөлхтөнд ёс суртахууны хэм хэмжээ байдгийг материаллаг бус субстанции (оюун ухаан) оршиж байгаагаас үүдэн тайлбарлах хэрэгтэй гэж үзэж байсныг бид эргэн санах хэрэгтэй.

Гэвч тоон онолын хандлагыг барьж байгаа цагт бид амьдралыг, ухамсрыг тодорхойлох нягт нарийн мэдээллийг гарган илэрхийлэх бололцоогүй. Иймд бодит байдлын тухай хялбарчилсан бус үзэл баримтлалыг хүлээн зөвшөөрч, материаллаг тайлбаруудаас татгалзах явдал оршихуйн дээд чанаруудын тухай нарийн мэдээллийг авч боловсруулах бололцоог нээж өгөх юм гэж Америкийн эрдэмтэн Томпсон үзэж байна.

Мэдээллийн дээд агуулгатай загвар бүтцүүд нь тоон шинжилгээний арга зүйн хүрээнд тайлбарлагдах бололцоогүй байгааг байгаль шинжлэлийн шинэ ололтууд нотолж байна.

Амьдрал болон бие хүний үндсэн шинж чанаруудыг, үүнд ялангуяа хүний нийгмийн шинж чанарыг тодорхойлохын тулд мэдээллийн ямар хэмжээний багтаамж хэрэгтэй болох вэ гэсэн асуудал аяндаа үүсч байна.

Ёс суртахууны үнэт зүйлс, чанар, хэм хэмжээг тодорхойлоход тухайлбал, сайн санаа, итгэлцэл ойлголцол, зусардал, бялдуучлал, эргэлзээтэй аймхай, атаархалтай, дээрэнгүй, ичгүүргүй бардам, эсвэл: үнэнч шударгуу, өршөөлтэй хүндэтгэлтэй, энэрэнгүй, ичимхий, нийгүүлсэнгүй тайван, хүлцэнгүй амгалан, зүтгэлтэй, бахархалтай, хүндэтгэлтэй бишрэлтэй гэх мэтчилэн бие хүний бусад олон шинж төлөвийг тодорхойлоход мэдээллийн агуулгын ямар багтаамж хэрэгтэй болохыг төсөөлөхөд ч бэрх юм.

Эдгээрийг тоон хэмжигдхүүнтэй эмпирик судалгааны аргаар тодруулах бололцоогүй байна. Танин мэдэхүйн энэ хязгаарлагдмал талыг даван туулах

оролдлого хийсэн нэг жишээ бол: квантын механик онолыг үндэслэгч Бор, Гейзенберг нар нь юмс, үзэгдлийн үндсэнд байх мэдээллийн долгионлог чанарын тухай асуудлыг байгаль шинжлэлд шинээр боловсруулан оруулсан явдал байв.

Гэвч ухамсрын тухай асуудлыг квантын механикт оруулах нь эрт байна гэж байгаль шинжээчид үзэж байна. Шинжлэх ухаан нь одоогоор ухамсрын тухай хангалттай мэдлэг мэдээллийг хуримтлуулан боловсруулж чадаагүй байсаар байгаагаас энэ нөхцөл байдал шалтгаалж байна.

Амьдрал, ухамсар гэх мэт маш нарийн бүтэцтэй хэлбэрүүдийг тайлбарлахад энэ бүтэц хэлбэрийн тухай мэдээллээс илүү нягт нарийн, дээд агуулгатай тайлбарлалаас эхлэх хэрэгтэй болдогийг мэдээллийн онол нотолж байна.

Бие хүний амьдрал үйлийн зорилгыг хэрэгжүүлэх, ертөнц ба бие хүний тэнцвэрийг нөхөн сэргээх, оршихуйг нэгдмэлжүүлэх үндсүүдийг тодруулахад мэдээллийн ба системийн онолын хандлага чухал ач холбогдолтой болж байна.

Орчлон ертөнц бол нэгдмэл орон зай юм. Энэ орон зай бол нэгдмэл тогтолцоо юм. Энэ орон зайд дамжуулах ба солилцох мэдээллийн чанар ямар байхаас хамаарч эерэг ба сөрөг мэдээллийг дамжуулах, солилцох явцад бидний үүрэг хариуцлага биелэгдэж байдаг ажээ.

Нэгдмэл оюунлиг мэдээллийн орон зайд бид амьдарч байна. Ертөнцийн нэгдэл түүний ухамсарт-оюунлиг чанарт байна гэж дүгнэж болох шинэ үе шат руу бид улам хурдтай ойртсоор байна. Амьдралыг зүй зохистой аргаар нөхөн сэргээх явдал бол эерэг мэдээлэл дамжуулах явдал мөн.

Нэгдмэл чанартай ертөнцийн орон зайд бид янз бүрийн чанартай мэдээллийг дамжуулж байна. Энэ мэдээллийн чанараас бидний амьдралын чанар тэр чигээрээ хамааран тодорхойлогдож байна. Тэгвэл энэхүү олон чанартай мэдээллийн орон зайгаас бид хэрэгцээтэй мэдээллээ олж авахын төлөө өглөөнөөс орой болтол идэвхийлэн зүтгэдэг боловч энэ хэрэгцээ маань тэр болгон хангагдаад байдаггүйг бид мэднэ. Учир нь бид мэдээллийн энэ аугаа их далайд өөрсдийн зүгээс ямар чанартай, ямар мэдээллийг дамжуулж амжсан билээ гэдгээ тэр бүр ухамсарлан явдаггүй билээ. Өгснөө

эргүүлэн авдаг жам бол нэгдмэл мэдээллийн орон зайд зайлшгүй хэрэгжих зүй тогтол буй заа.

Тарнийн танин мэдэхүйн аргаар мэдээллийг дамжуулах аргыг хүмүүс эртний үеээс хэрэглэж иржээ. Тарнийн программчлал онцгой ач холбогдолтой байж болохыг бид анхаарч үзэх хэрэгтэй гэдгийг олон эрдэмтдийн судалгаа харуулж байна. "Хамгийн сүүлийн үеийн систем динамик загварын зарчмууд нь их нууц тарнийн ёсны шаталсан тогтолцоот логик утга агуулгатай таарч байна" хэмээн доктор Б.Болдсайхан үзэж байна.(Үз:Б.Болдсайхан.Буддизм ба шинжлэх ухаан" УБ,2003 он)

Ертөнцийн тэнцвэрийг нөхөн сэргээх, мөн энэ тэнцвэрийг алдагдуулах

үндсэн 2 арга зам буй:

1. буян бүтээх буюу эерэг позитив мэдээллийг дамжуулах , солилцох, хөтөлбөржүүлэх арга , ийм аргаар амьдарсан хүмүүн өөртөө эргүүлээд хийморь буянхишиг хуримтлуулдаг хэмээн манай ард түмэн нэн эртний үеээс эхлэн үзэж ирсэн байна.

2. аминч үзэл буюу ертөнцийг өөрийн "би"-д явцууруулан хашиж, зөвхөн өөрийгөө абсолют мэтээр үзэх нь өөрийнхөө дотоод мөн чанараас өөрийгөө эвдэн бусниулах явдалд хүргэдэг байна.

Сөрөг хөтөлбөржилтийг устгах арга бол тарнийн хөтөлбөрийн арга юм. Ертөнцөд эерэг ( позитив ) мэдээллийг дамжуулах явдал нэн чухал болсон онцгой цаг үед бид амьдарч байна. Эерэг мэдээллийн солилцоо улам бүр хомсдож байгаа цаг үед энэ эерэг мэдээллийн гачигдлыг даван туулах хэрэгцээ цаашид улам бүр өсөх болно. Ийм нөхцөлд тарнийн танин мэдэхүйн ач холбогдол өсөн нэмэгдэж байна.

Системийн онол, систем динамик загварын үүднээс бие хүний санаа сэдэл, үзэл баримтлал, эрхэмнэл, үнэт зүйлсийг, товч хэлбэл ухамсрыг авч үзэх бололцоотой.

Систем динамик загвар нь материйн өөрөөсөө үүдэж зохион байгуулагдах чанарыг болон мэдээллийн нэгдмэл урсгалт чанарыг тусган илэрхийлэх боломжийг бидэнд олгох магадлалтай.

Гагцхүү системийн шинжилгээний арга нь тоон илэрхийллээс чөлөөтэй байх нөхцөлд энэ чиглэлийн судалгааг гүйцэтгэх бүрэн бололцоотой болно хэмээн бид үзэж байна.

Дээд агуулгын багтаамжтай бүтцүүдийг дамжуулах, илэрхийлэх арга болох систем динамик загварын аргаар бид хүмүүний оршихуйн зарим суурь чанаруудыг тодруулах бололцоог олж чадна хэмээн найдахдаа үүнд ялангуяа ёс суртхууны эрхэм дээд үнэт зүйлс нь гүн ухааны онтологийн нэн чухал асуудал, бүрэлдэхүүн хэсэг болж байдаг тухай мэдлэгийг тодруулан үзэх бололцоотой болно хэмээн итгэж байна.

Ёс зүйн шинжлэх ухаан өөрийн жинхэнэ үүрэг зориулалтаараа харилцан хамаарлын тухай шинжлэх ухаан байж, өөрийн категорийн аппарат, ай ухагдахууны тусламжтайгаар орчлонгийн тэнцвэрийг хадгалах, нөхөн сэргээх үүргийг онцлон гүйцэлдүүлэх чиг зорилгыг баримталбал зохино хэмээн бид дүгнэж байна.

#### **Ашигласан ном, зохиол**

1. Б.Болдсайхан. Буддизм ба шинжлэх ухаан. УБ, 2003 он.
2. Mechanistic and non-mechanistic science. An Investigation into the nature of Consciousness and Form. New Delhi, 2002
3. Mysteries of the Sacred Universe. The cosmology of the Bhagvata Purana. Richard L.Thompson.New Delhi, 2002.
4. Philosophical Consciousness and Scientific Knowledge. Vol 11, part 1. New Delhi, 2004.
5. Invincibility for Every Nation. Maharishi Mahesh Yogi. The Netherlands, 1999.